

УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛЬ

ISSN 2310-256X



Археологи, Түүх, Хүмүүнлэгийн ухааны сэтгүүл

Улаанбаатарын Их Сургуулийн сэтгүүл
Дугаар 12(11)

Улаанбаатар
2016

DDC
907.2.05
J-80

Улаанбаатарын Их Сургуулийн
Эрдмийн зөвлөлийн баталснаар хэвлэв.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ:

Дарга:

Д.Эрдэнэбаатар. Доктор /Ph.D/, профессор

Гишүүд:

Д.Баярсайхан. Доктор /Ph.D/

С.Туул. Доктор /Ph.D/

Н.Хишигт. Доктор /Ph.D/, дэд профессор

С.Цолмон. Доктор /Ph.D/, профессор

Нарийн бичгийн дарга:

Д.Баярсайхан. Доктор /Ph.D/

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5-р хороо

Шуудангийн 51-р салбар, 167-р хайрцаг.

Утас: (976-1-) 453538

Факс: (976-1-) 458327

E-mail: info@ubstate-univ.mn

www.ubstate-univ.mn

© Since 2005, Ulaanbaatar State University

Printed by Soyombo Printing Co.,LTD, Ulaanbaatar, Mongolia

**АРХАНГАЙ АЙМГИЙН БАТЦЭНГЭЛ СУМЫН ХӨШӨӨН ДЭНЖИД
ЯВУУЛСАН ТҮРЭГИЙН ҮЕИЙН ТАХИЛЫН БАЙГУУЛАМЖИЙН
МАЛТЛАГА СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС**

Т.Идэрхангай*, А.А.Тишкин, Б.Б.Горбунов***,
Ч.Мөнхбаяр****, Н.Н.Серегин*******

* Монгол улсын Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхимийн
багш, магистр, E-mail: iderkhangai2007@yahoo.com

** ОХУ-ын Барнаул Хотын Алтайн Улсын Их Сургуулийн Археологи, Угсаатны зүй,
Музей судлалын тэнхимийн эрхлэгч, археологич. E-mail: tishkin210@mail.ru

*** ОХУ-ын Барнаул Хотын Алтайн Улсын Их Сургуулийн Археологи, Угсаатны зүй,
Музей судлалын тэнхимийн багш, археологич. E-mail: gorbunov@hist.asu.ru

**** Монголын Улсын Ховд Их Сургуулийн Түүхийн тэнхимийн багш, археологич. munkh_boroldoi@yahoo.com

***** ОХУ-ын Барнаул Хотын Алтайн Улсын Их Сургуулийн Археологи, Угсаатны зүй,
Музей судлалын тэнхимийн багш, археологич. E-mail: nikolay-seregin@mail.ru

Түлхүүр үг: Архангай, Батцэнгэл, Түрэгийн үе, тахилын онгон, Хөшөөн дэнж, буган хөшөө, адууны шүд

Хураангуй: Уг өгүүлэлд Монгол-Оросын хамтарсан археологийн хээрийн судалгааны ангийн Архангай аймгийн Батцэнгэл сумын Улаан чулуу багийн нутаг Хөшөөн дэнж-ІҮ хэмээх газарт зэрэгцээ орших Түрэгийн үеийн 4 тахилын онгоноос хойд талаасаа 2 дахь тахилын онгоныг малтан судалсан судалгааны үр дүнг хэвлэн нийтэлж байна.

Монгол улсын Шинжлэх Ухаан Технологийн сан, ОХУ-ын Хүмүүнлэгийн сангийн фондноос (РГНФ) шалгарсан “Монгол Алтайн түүх соёлын дурсгалыг цогцолбороор нь нарийвчлан системтэйгээр судлах” төслийг 2013 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд төслийн багийн судлаачид тус онд Ховд аймгийн Ховд сумын Харганат I –т хүрэл зэвсгийн үеийн дугуй булш 3, Харганат II –т түрэгийн үеийн тахилын онгон 2, Бэлэн Ус –I хэмээх газарт чемурчекийн соёлын булш 1, Буянт сумын Улаан худаг I –т 10-р хиргисүүрийг тус тус малтан судалсны зэрэгцээгээр Цамбагаравын Хар хад хэмээх газарт өвч хуягласан морин цэргийн дүрслэл бүхий хадны зургийг нарийвчлан судалж¹ судалгааны ажлаа хийж гүйцэтгэсэн билээ. Харин төслийн багийнхан 2014 онд судалгааны цар хүрээгээ тэлэн баруун Монголын бүс нутгийн хүрэл болон түрэгийн үеийн дурсгалуудыг Монгол орны төвийн бүс нутгийн энэ үеийн зарим дурсгалуудтай харьцуулан бүс нутгийн болон угсаа соёлын онцлог, ялгаа буй эсэхийг тодруулах зорилгоор судалгааны ажлаа Архангай аймгийн Батцэнгэл сумын Улаан чулуу багийн нутаг Хөшөөн дэнж хэмээх газарт явуулсан болно. Тус хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд зохиогчдоос гадна ОХУ-ын Барнаул хотын Алтайн Улсын Их Сургуулийн Археологи, Угсаатан, Музей судлалын тэнхимийн археологич С.Ф. Грушин (Sc.D), Т.С. Паршикова (МА), О.С. Лихачева (МА), Кемеровын Их Сургуулийн археологийн тэнхимийн багш, археологич А.Н.Мухарева (Ph.D) болон бусад судлаачид оролцон ажиллалаа.

Батцэнгэл сумын Түрэгийн үеийн тахилын онгоны судалгааны байдал

Монгол нутаг дахь Түрэгийн үеийн тахилын онгоны анхны судалгааны ажлыг Шинжлэх Ухааны зорилгоор 1876-1878 онуудад Төв Азийг судлагч нэрт эрдэмтэн Г.Н. Потанин эхлүүлсэн байдаг бол Архангай аймгийн Батцэнгэл сумын Түрэгийн үеийн тахилын онгоны судалгааг 1906 онд Финландийн эрдэмтэн И.Г. Гране Тоглохын тал хэмээх газарт язгууртны нэгэн тахилын онгоныг нээн илрүүлснээр эхэлжээ². Түүний дараагаар энэ дурсгалыг 1956-1957 онд Ц. Доржсүрэн үзэж тэмдэглэсэн³ бол, 1980 онд Н.Сэр-Оджав, В.Е.Войтов, Д.Баяр нар Хар Хорум, Хар Хул хааны балгасанд малтлага судалгаа явуулан, Хар Хул хааны балгасны ойр орчимд археологийн хайгуул судалгаа явуулаад буцах замдаа

¹ Мөнхбаяр Ч. Ховд Их Сургуулийн НХУС-ийн Түүхийн тэнхимийн Археологийн хээрийн танилцах дадлагын (2012-2013 оны хичээлийн жил) тайлан. ХоИС-ийн ГБСХ, Улаанбаатар

² Grano.J.G. Archaeologische Beobachtungen von meiner Reise in Suedsibirien und der Nordwest Mongolei im Jahre 1909. Helsingfors, 62

³ Доржсүрэн Ц. 1956-1957 онуудад Архангай аймагт археологийн шинжилгээ хийсэн нь. // Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл, Улаанбаатар, т.94.

Архангай аймгийн Батцэнгэл сумын нутгаар дайран Тоглохын талын язгууртны тахилын онгоны тойм зургийг үйлдэн хоёр хүн чулуу болон чулуун хонины талаар товч тодорхойлолт бичсэн байна⁴. 1987 онд МЗТСХЭ-ийн Хангайн Отрядын Д. Баяр, В.Е. Войтов нар мөн Тоглохын талын тахилын онгоны ерөнхий дэвсгэр зургийг үйлдэн хүн чулууд, чулуун хонь, хашлага чулуудын гар зургийг үйлдэхийн хамт Батцэнгэл сумын Шивэртийн Ам хэмээх газарт цэцгэн хээ бүхий дөрвөлжин хашлагыг малтан судлаж гэрэл болон гар зургаар тус тус баримтжуулжээ⁵. Тиймээс тус бүс нутгийн Түрэгийн үеийн тахилын онгоны судалгаа зөвхөн Тоглохын талын нэг л дурсгалт газрын судалгаагаар хязгаарлагдаж байв. Харин 2009 оноос эхлэн Улаанбаатарын Их Сургуулийн Археологи, Түүхийн тэнхимийн оюутны зуны хээрийн танилцах болон үйлдвэрлэлийн дадлагын маршрутыг тус сумын нутгаар дайруулан зохион байгуулах болсноор энэ бүс нутгийн түүх соёлын дурсгалын судалгаа улам өргөн цар хүрээг хамрах болсны нэг бол Түрэгийн үеийн тахилын онгоны судалгаа юм.

2010 онд Улаанбаатарын Их Сургуулийн Археологи, Түүхийн тэнхимийн оюутны зуны хээрийн танилцах болон үйлдвэрлэлийн дадлагын хүрээнд Архангай аймгийн Батцэнгэл сумын нутаг Дайрбор уул, Барчин, Дунд Оорцог хэмээх газруудад өмнөх жилийн судалгаагаа гүнзгийрүүлэн Хүннү булшнуудын дэвсгэр зургийг дахин үйлдсэний зэрэгцээгээр шинээр Дайрбор багийн нутаг Хөл толгойд 2.5 x 2.4 м хэмжээтэй хашлага чулуун дотор зүүн хойш налан унасан 3.58 м өндөр буган хөшөө, Дунд Оорцог уулын баруун тал, Булгийн Шуудууны зүүн дэнжид зэрэгцээ орших Түрэгийн 5 тахилын онгоныг нээн илрүүлж, бүртгэн тэмдэглэсэн болно⁶.

2010 оны 10 сард Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхим, Архангай аймгийн Батцэнгэл сумын Засаг Даргын Тамгын Газрын хамтын ажилгааны гэрээ ёсоор хоёр долоо хоногийн хугацаатай тус сумын бүх нутаг дэвсгэрээр археологийн хайгуул судалгааг явуулж үе үеийн 2000 орчим түүх соёлын дурсгалыг нээн илрүүлж судласнаас Түрэгийн (МЭ VI-VIII) үед холбогдох тахилын онгоныг 23 дурсгалт газар нийт 60 нээн илрүүлэн олсон нь түрэгүүд энэ бүс нутагт тодорхой хэмжээгээр нутаглан аж төрж байсныг батлах баримт болно. Мөн үүнээс гадна эдгээр тахилын онгоны дунд дугуй хэлбэрийн тахилын байгууламж бүртгэгдсэн нь Монгол орны нутгаас урьд өмнө илрэн олдож байгаагүй онцгой тохиолдол байв⁷.

2012 оны 7 сард Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхимийн оюутны зуны хээрийн үйлдвэрлэлийн дадлагын хүрээнд 2010 онд нээн илрүүлсэн Архангай аймгийн Батцэнгэл сумын Хөнгө багийн нутаг Дунд Оорцог хэмээх газарт орших гадаад хэлбэрийн хувьд дугуй болон дөрвөлжин хоёр өөр хэлбэртэй Түрэгийн үеийн 5 тахилын онгоныг малтан судалж хэвлэн нийтлүүлсэн билээ⁸.

2013 онд Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхимийн багш Т. Идэрхангайгаар ахлуулсан судалгааны баг өөрсдийн боломжинд тулгуурлан 2010 онд Архангай аймгийн Батцэнгэл сумын нутгаар хийж гүйцэтгэсэн хайгуул судалгааны ажлыг үргэлжлүүлэн тухайн онд орхисон газруудаар 21 хоногийн хугацаатай хайгуул судалгааг явуулж шинээр 261 газар 1055 дурсгалыг бүртгэн баримтжуулснаас Түрэгийн үеийн тахилын онгон 12 дурсгалт газар 30 тэмдэглэсэн бөгөөд тэдгээрийн дотор Хөшөөн дэнжийн дурсгал хамрагдсан билээ⁹.

2014 онд Монгол-Оросын хамтарсан “Монгол Алтайн түүх соёлын дурсгалыг цогцолбороор нь нарийвчлан системтэйгээр судлах” төслийн Монгол улсын Улаанбаатарын Их Сургуулийн Археологийн тэнхим, Монгол улсын Ховд хотын Ховдын Их Сургуулийн Түүхийн тэнхим, ОХУ-ын Барнаул Хотын Алтайн Улсын Их Сургуулийн Археологи, Угсаатан, Музей судлалын тэнхимийн хамтарсан судалгааны баг Архангай аймгийн Батцэнгэл сумын Улаанчулуу багийн нутаг Хөшөөн дэнж хэмээх газарт Түрэгийн үеийн хойноос урагш цувран зэрэгцэн орших 4 тахилын онгоноос хойд талаасаа 2 –

⁴ Сэр-Оджав Н., Баяр Д. 1979-1980 оны Хар Хорумын шинжилгээний ажлын тайлан. ШУА-ийн ТХГБСХ, Улаанбаатар. т.29.

⁵ Баяр Д. 1987 оны хээрийн шинжилгээний тайлан. ШУА-ийн ТХГБСХ, Улаанбаатар. т. 2-5.

⁶ Эрдэнэбаатар Д., Идэрхангай Т., Мижиддорж Э., Галбадрах Б., Оргилбаяр С. Улаанбаатарын Их сургуулийн Нийгмийн ухааны факультетийн Археологи, Түүхийн ангийн оюутнуудын хээрийн танилцах ба үйлдвэрлэлийн дадлагын 2010 оны тайлан. // УБИС-ийн НУФ-ийн Археологийн тэнхимийн ГБСХ. Улаанбаатар.

⁷ Идэрхангай Т., Бадрах Б., Галбадрах Б., Эрдэнэ Ж., Мөнгөншагай А., Амарболд Э. Архангай аймгийн Батцэнгэл сумын нутагт явуулсан археологийн хайгуул судалгааны ажлын 2010 оны тайлан. УБИС-ын НУФ-ийн Археологийн тэнхимийн ГБСХ, Улаанбаатар

⁸ Идэрхангай Т., Эрдэнэбаатар Д., Эрдэнэ Ж., Батхүү Г. Дунд Оорцогийн эртний түрэгийн (МЭ YI-YIII) тахилын онгоны малтлага судалгааны үр дүнгээс. // Journal of Archaeology, History and Culture (Journal of the school of Ulaanbaatar, NUM Volume 8 (7) November 2012), Улаанбаатар, т. 86-95

- Идэрхангай Т. Результаты раскопок тюрокских оградок в местности Дунд Оорцог (Центральная Монголия). // Известия Алтайского государственного университета, Издательство: Алтайский государственный университет, № 4/2 (84), Серия: История, Политология, Барнаул, стр. 121-127

⁹ Идэрхангай Т., Бадрах Б. Архангай аймгийн Батцэнгэл сумын нутагт явуулсан археологийн хайгуул судалгааны ажлын 2013 оны тайлан. УБИС-ын Археологийн тэнхимийн ГБСХ, Улаанбаатар, т. 115-122.

